



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар А/603

Улаанбаатар хот

ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгалийн ургамлын тухай хуулийн 7¹ дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Нэн ховор, ховор, зарим элбэг ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
- 2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газар /Ц.Уранчимэг/-т даалгасугай.
- 3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/677 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Б.БАТ-ЭРДЭНЭ